



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнхэр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/013/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Архангай аймаг  
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141  
Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)  
Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860  
Цахим хаяг: [Nerguibaatar@audit.gov.mn](mailto:Nerguibaatar@audit.gov.mn)  
Аудитор **А.Пүрэвцэцэг**  
Цахим хаяг: [Purevtsetsega@audit.gov.mn](mailto:Purevtsetsega@audit.gov.mn)

## **Агуулга**

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	8
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	9
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	10
<b>5. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	11

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол улсын засгийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХГБХХГ	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР  
СУМЫН ЗАСАГ ДАРГА Ч.БАРМИД ТАНАА

2025.03.25 № 159  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Цэнхэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Цэнхэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Сумын хоршоо хөгжүүлэх сангаас олгосон 24,501.5 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй;

Энэ нь Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-тай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Аудитын гол асуудал

Тайлант онд сумын төсвийн 22 нэр төрлийн орлогоор 905,583.6 мянган төгрөг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,740,549.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг нийт дүнгээр 92.2 хувиар давуулан биелүүлжээ.

Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 9 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 3,611,647.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,823,755.0 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 787,892.2 мянган төгрөг зарцуулагдаагүй байна. Энэ нь ОНХС, ХХС-нд төлөвлөснөөс 639,288.3 мянган төгрөг зарцуулагдаагүй, төсөвт байгууллагуудын үлдэгдэл 148,603.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Цэнхэр сумын Засаг дарга нь 2024 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 15 үндсэн зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 75.6 хувьтай үнэлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	925,340.54	2,013,159.97
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	477,686.17	1,514,001.57
33	АВЛАГА	363,966.70	358,170.00
35	БАРАА МАТЕРИАЛ	63,687.67	81,921.51
36	НӨӨЦИЙН БАРАА	20,000.00	59,066.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,362,408.82	3,634,089.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,362,408.82	3,634,089.98
39200	Биет хөрөнгө	3,105,198.82	3,377,369.98
39300	Биет бус хөрөнгө	257,210.00	256,720.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,287,749.36	5,647,249.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	32,640.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	32,640.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,287,749.36	5,614,609.96
51	Засгийн газрын хувь оролцоо	4,287,749.36	5,614,609.96
51200	Хуримтлагдсан үр дүн	3,363,878.57	4,690,739.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	267,507.22	267,507.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,287,749.36	5,647,249.96

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,890,043.38	4,466,327.96
11	ТАТВАРЫН ОРЛОГО	705,024.22	1,423,215.50
110	Орлогын албан татвар	295,013.03	759,958.44
1100	Хувь хүний орлогын албан татвар	294,832.03	759,785.44
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	181.00	173.00
113	Хөрөнгийн албан татвар	119,266.72	69,053.00
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	-	-
118	Бусад татвар, төлбөр, хураамж	290,744.46	594,204.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	643,937.47	957,604.42
120	Нийтлэг татварын бус орлого	643,937.47	957,604.42
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,541,081.69	2,085,508.04
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,236,245.30	2,108,577.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,236,245.30	2,108,577.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,530,638.35	2,033,320.22

**Архангай аймгийн Цэнхэр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,310.31	877,848.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,357.39	111,063.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	168,618.44	278,800.64
2104	Хангамж, бараа материалын зардал	70,291.50	97,449.73
2105	Нормативт зардал	46.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,410.66	42,584.90
2107	Томилолт, зочны зардал	9,020.60	12,398.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,456.57	225,440.19
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	408,126.88	387,735.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,705,606.94	75,256.87
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	653,798.08	2,357,750.88
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	425,889.98	1,026,862.57
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	227,908.10	1,330,888.31

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,478,366.47	3,962,503.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	705,024.22	1,423,215.50
110	Орлогын албан татвар	295,013.03	759,958.44
1100	Хувь хүний орлогын албан татвар	294,832.03	759,785.44
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	181.00	173.00
113	Хөрөнгийн албан татвар	119,266.72	69,053.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	290,744.46	594,204.05
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	36,256.27	37,352.55
1181	Газрын төлбөр	58,225.73	383,488.72
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	196,262.47	173,362.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	232,260.56	441,517.96
120	Нийтлэг татварын бус орлого	232,260.56	441,517.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,541,081.69	2,097,770.04
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,986,552.81	1,796,547.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,986,552.81	1,796,547.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,280,945.87	1,721,290.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,230.31	877,848.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,357.39	111,063.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,550.00	246,160.64
2104	Хангамж, бараа материалын зардал	73,932.50	90,572.28

**Архангай аймгийн Цэнхэр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,520.00	43,134.90
2107	Томилолт, зочны зардал	9,020.60	12,398.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	379,460.74	227,015.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,874.33	113,097.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,705,606.94	75,256.87
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	491,813.66	2,165,956.47
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	635,919.61	1,024,641.07
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	635,919.61	1,024,641.07
2200	Дотоод эх үүсвэрээр	635,919.61	1,024,641.07
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(635,919.61)	(1,024,641.07)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(65,000.00)	(105,000.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	65,000.00	105,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(209,105.96)	1,036,315.40
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	686,792.13	477,686.17
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	477,686.17	1,514,001.57

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	656,363.57	4,059,841.26
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	656,363.57	4,059,841.26
3	Тайлант үеийн үр дүн	-	227,908.10
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	656,363.57	4,287,749.36
9	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	656,363.57	4,287,749.36
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(4,027.70)
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	656,363.57	4,283,721.66
13	Тайлант үеийн үр дүн	-	1,330,888.31
19	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	656,363.57	5,614,609.96

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,611,647.20	2,823,755.05	787,892.15	21.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,850,252.80	1,701,648.98	148,603.82	8.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,778,185.90	1,630,292.12	147,893.78	8.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	916,382.10	877,848.08	38,534.02	4.21

**Архангай аймгийн Цэнхэр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,522.80	111,063.25	3,459.55	3.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	281,549.30	246,160.64	35,388.66	12.57
2104	Хангамж, бараа материалын зардал	84,728.40	81,362.28	3,366.12	3.97
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,500.00	25,494.90	5.10	0.02
2107	Томилолт, зочны зардал	13,300.00	12,398.00	902.00	6.78
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	251,253.80	193,081.25	58,172.55	23.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,949.50	82,883.71	8,065.80	8.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,066.90	71,356.87	710.03	0.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,066.90	71,356.87	710.03	0.99
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,653,444.40</b>	<b>1,017,106.07</b>	<b>636,338.33</b>	<b>38.49</b>
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>107,950.00</b>	<b>105,000.00</b>	<b>2,950.00</b>	<b>2.73</b>
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,611,647.20</b>	<b>3,081,288.25</b>	<b>530,358.95</b>	<b>14.68</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,160,951.20</b>	<b>2,955,587.88</b>	<b>205,363.32</b>	<b>6.50</b>
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>450,696.00</b>	<b>125,700.36</b>	<b>324,995.64</b>	<b>72.11</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	268,615.87	-268,615.87	100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	526,149.07	-526,149.07	100.00
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>78.00</b>	<b>78</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>3.00</b>	<b>3</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>36.00</b>	<b>36</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	102,433.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	102,433.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	98,533.04
2104	Хангамж, бараа материалын зардал	9,210.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,175.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,934.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,213.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,900.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>102,433.04</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	102,433.04

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Цэнхэр сум нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй.

Тус сум нь тайлант онд “Бид иргэдийнхээ сэтгэл ханамжийг эрхэмлэн дээдэлж, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн, сайжруулах замаар Олон улсын жишигт хүрсэн төрийн үйлчилгээг бий болгох” гэсэн зорилт тавьж ажиллажээ. Гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 90.0%-аар үнэлжээ.

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй 2 зөрчил<sup>1</sup> илэрч зөрчлийг арилгуулах нэг албан шаардлага, давтан гаргахгүй байх нэг зөвлөмж тус тус хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 24,501.5 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлснээс гадна сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн албаны хяналтын үр дүнтэй холбоотой санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын 13,909.0 мянган төгрөгийн зөрчлийн нөлөөллийг үнэлж нийт 38,410.5 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг зөрчил гэж үзлээ. Энэ нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **25,281.5** мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

Архангай аймгийн Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 0196 тоот шүүгчийн захирамжийн дагуу ШШГГ-аас иргэн П.Эрдэнэтөгсөөс 10,798.5 мянган төгрөгийг төлүүлж үлдэх 8,351.5 мянган төгрөгийг төлүүлэхээр ажиллаж байх үед Цэнхэр сумын Засаг даргын 2021.06.30-ны өдрийн 01/191 дугаар албан бичгээр холбогдох материалыг буцаан татаж шүүхийн шийдвэрийг цуцлуулсан, иргэн Д.Мөнхтөрөөс 2014 оноос огт эргэн төлөлт хийгээгүй 16,150.0 мянган төгрөг, нийт 24,501.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй, хоршоо хөгжүүлэх санд хохирол учруулсан зөрчил илэрлээ

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10 дугаар зүйлийн 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина”, 10.5-д “Зээлдэгчийн гэрээнд эрсдэл үүссэн тохиолдолд зээлийн хөрөнгийг эргүүлэн татах ажиллагааг сумын Засаг дарга болон хяналтын зөвлөл хариуцан зохион байгуулна, Энэхүү зохицуулалтыг зээлийн гэрээгээр нарийвчлан зохицуулна”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Иргэн П.Эрдэнэтөгс, Д.Мөнхтөр нартай холбоотой хугацаа хэтэрсэн чанаргүй авлагын үлдэгдлийг барагдуулах, буруутай албан тушаалтнаар төлүүлэх, хариуцлага тооцуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч биелэлтийг ирүүлэх

#### 3.2 Зөвлөмж

##### 3.2.1 Дотоод хяналттай холбоотой

Илрүүлэлт: Тайлант онд сумын засаг даргын санхүүгийн алба, төрийн сангаас өдөр тутам төсвийн гүйлгээнд тавих хяналт муу байгаагаас төсвийн шууд захирагч нарын тайланд 13,909.0 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.5, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.9.7 дахь заалтыг зөрчсөн байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Өгсөн зөвлөмж:** Сумын Засаг даргын дотоод хяналт, төсвийн байгууллагуудын гүйлгээнд сумын санхүүгийн алба, төрийн сангаас тавих өдөр тутмын хяналтын үр дүнг сайжруулах арга хэмжээг авч үр дүнг үнэлэх зөвлөмж хүргүүлээ.

*Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/ Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХХС-тай холбоотой	1	24,501.5	-	-	1	24,501.5	-	-	-	-	-	-
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1</b>	<b>24,501.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>24,501.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/ Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн данс	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-

**5. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	8	10,930.0	1	2,202.1	7	8,727.9						
ИТХ	3	2,979.0			3	2,979.0	-	-	-	-	-	-
ХХС	-	-			-	-						
ОНХС	1	24,501.5	-	-	1	24,501.5						
Шилэн данс	1						1					
<b>Дүн</b>	<b>13</b>	<b>38,410.5</b>	<b>1</b>	<b>2,202.1</b>	<b>11</b>	<b>36,208.4</b>	<b>1</b>					